



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/503

Номгон

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын түргэвчилсэн
оношлуурын нөөцийг нэмэлтээр бүрдүүлэх
тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 46 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын түргэвчилсэн оношлуурын нөөцийг бүрдүүлэх ажлыг яаралтай зохион байгуулсугай.

2.Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх оношлуурыг татан авч, аймгийн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т үүрэг болгосугай.

3.Түргэвчилсэн оношлуурт шаардагдах 80.000.000 (Наян сая) төгрөгийг Засаг даргын нөөцөөс санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210161

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 09-ны
өдрийн А/503 дугаар захирамжийн хавсралт



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТҮРГЭВЧИЛСЭН
ОНОШЛУУРЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуур	5000	16000	80.000.000

-----oOo-----